



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/352

Номгон

Иргэн Ц.Ариунтуяа, Б.Сангижадамба, Ч.Баянаа
нарт газар эзэмшүүлэх тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн "Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай" 81 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 508ж тоот хаягт байрлах 17-р байрны өргөтгөлийн зориулалтаар иргэн Ц.Ариунтуяагийн (ВЮ72030563) эзэмшихийг хүссэн 43 м2 газрыг, Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 512а тоот хаягт байрлах 19-р байрны өргөтгөлд үйлчилгээ явуулдаг иргэн Б.Сангижадамбын (ВЭ80041014) үл хөдлөх хөрөнгийн доорхи 63 м2 газрыг, Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 508з тоот хаягт байрлах 17-р байрны өргөтгөлд үйлчилгээ явуулдаг иргэн Ч.Баянаагийн (ВЮ76040105) 32 м2 газрыг тус тус дуудлага худалдааны анхны үнийг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай



621010893